



ДУНДГОВЬ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/06

Аргатай

Хорио цээрийн дэглэм
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 32 дугаар зүйлийн 32.1.8, 32.1.9, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.2.1 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 266 дугаар тогтоол, Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам, Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 23-1504, 23-1505 бүртгэлийн дугаартай шинжилгээний дүнг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Энгэр-Ус 2 дугаар баг, Аргатай 3 дугаар багийн нутаг дэвсгэрт бог малын гоц халдварт мялзан өвчний голомт үүссэн тул 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрөөс сумын төвийн анхны голомтоос 10-20 километрийн радиуст өвчний шинж тэмдэг, сэжиг илэрсэн нэр бүхий малчин өрхүүдийг хамруулан хорио цээрийн дэглэм тогтоосугай.


2. Бог малын гоц халдварт мялзан өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд Гамшгаас хамгаалах бие бүрэлдэхүүнийг үүрэгжүүлж ажиллахыг сумын онцгой комиссын шуурхай штабын дарга (Р.Отгонбаатар)-т үүрэг болгосугай.

3. Хорио цээрийн бүсийн малын хөдөлгөөнд хяналт тавьж, захирамжийг иргэдэд сурталчлан хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хэсгийн цагдаа (Б.Далхсүрэн), Багийн засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Хорио цээрийн бүсэд хийгдэх ариутгал халдваргүйтгэл хийх, малын эрүүл мэндийн үзлэгийг чанартай хийж, малын эмч нарыг мэргэжил арга зүйгээр хангаж, цааш дэлгэрүүлэхгүй байх ажлыг зохион байгуулж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн малын эмч (Ц.Батбилэг)-т үүрэг болгосугай.

5. Өвчний голомтын хүрээ тэлж байгаатай холбогдуулан малыг амьдаар худалдаалахгүй байх, отор нүүдэл хийхгүй байхыг нийт малчид, мал бүхий иргэдэд даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ **Б.ЗОЛЗАЯА**



This PDF local disk(D)2023он/эз-н актууд/захирамж 2023

482301028